

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 оны 09 дүгээр сарын мэдээлэл

2024.09.24.

“Овоот”

Нэг. Төрийн удирдлагын чиглэлээр:

-Зүүн бүсээс УИХ-д сонгогдсон 6 гишүүн “ЭРГЭХ ХОЛБОО” уулзалтыг суманд зохион байгуулж, иргэдэд мэдээлэл хийж, энэ үеэр төрийн дээд шагналаар 10 гаруй иргэнийг шагнаж урамшуулав.

-2024.09.10 ны өдөр Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг санан дурсах, тэдний дурсгалыг мөнхжүүлэх 29 дахь өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд сумын ИТХ-ын ажлын алба, ЕБС-тай хамтран 11-12 ангийн 50 гаруй хүүхдүүдийн дунд **"Монголд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлт, дүгнэлт, сургамж"** сэдвээр сургалтыг амжилттай зохион байгууллаа. Мөн сурагчдын дунд "АХА" тэмцээнийг зохион байгуулж 4 хүүхдийг шагнаж урамшууллаа.

-Сүхбаатар аймгийн Хууль эрх зүйн хэлтсийн даргын 2024.04.16 ны 08/454 дүгээр албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд сумын ИТХ-ын 11 тогтоолд нягтлан шалгалт хийж, үүнээс “Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр тооцох тухай”, “Нийтийн халуун усны үйлчилгээний үнэ тогтоох тухай”, “Орон нутгийн орлого бүрдүүлэх тухай” нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг хуулийн дагуу шинэчлэн батлуулахаар шийдвэрлэв.

Хоёр. Сургалт, сурталчилгааны чиглэлээр:

-Аймгийн УЗХороо, Онцгой байдлын газраас хамтарсан багийн сургалтыг зохион байгуулж, “Аврах бүлэг”-ийн гишүүд болон бусад төрийн албан хаагчдыг оролцууллаа.



-Аймгийн “ХАМТАРСАН БАГИЙН ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ”-ний баг суманд 2024.09.23 нд ажиллаж “ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ “ шинэчилсэн хуулийн хүрээнд сургалт зохион байгууллаа.

-“ЁС ЗҮЙН АЯН”-ыг 2024.09.01-2024.11.01 ний хооронд зохион байгуулж, удирдамж чиглэлээ байгууллагуудад хүргүүлэн, эхний ээлжинд сумын ЗДТГ-т “ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ”-г танилцуулах сургалт хийлээ.

Гурав. Хөдөө аж ахуйн болон төв суурингийн өвөлжилтийн чиглэлээр:

Суманд хадлангийн 14 салаа ажиллаж байна. Аюулгүй нөөцөд 1 тн өвс татаад байна. Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулаад ажиллаж байна.

Уг төлөвлөгөөний дагуу төв суурингийн өвөлжилтөд бэлтгэх ажлын хувьд төвийн нэгдсэн халаалтыг 2024.09.15 ны өдөр эхлүүлээд байна.

“Намрын ногоон өдрүүд-2024” арга хэмжээнд “Шилдэг суран эдлэл”, “Эмийн ургамал”, “Шилийн богдын цай” брэнд бүтээгдэхүүнээр шалгарч, сумаараа 2 дугаар байр шалгарч амжилттай оролцлоо.



Дөрөв. Эрүүл мэндийн чиглэлээр:

Монгол Улсын Хүний гавъяат эмч Г.Цулбуур 2024 оны 09-р сарын 10-18 өдрүүдэд Эрүүл мэндийн төвд ажиллаж дараах үйлчилгээг үзүүллээ.

1. Ходооны дуран /эхо-гоор/
2. Элэг, цөс, нойр булчирхай, бамбай ,бөөр
3. Хөхний эмгэг тодруулна /эхо-гоор/
4. Жирэмслэлт, ургийн гажиг, умайн дайварууд эмгэг илрүүлэх /2D,3D эхо-гоор

5. Үе мөчний өвчин, цусны сахар тус бүр багц үзлэгийг хийж 8 хоног ажиллаж нийтдээ 200 аад иргэнд үзлэг хийлээ.Энэ үеэр сумын ЭМТ-өөс орон байр, хоол ундаар ханган хамтарч ажилласан.

Мөн 2024 оны 9-р сарын 20-21-нд “Марал” эмнэлгийн дотор, хоол боловсруулах, дурангийн эмч Д.Оюунсүрэн үзлэг хийж, зөвлөгөө өгч хамтарч ажилласан.



“ДАРХЛААЖУУЛАЛТЫН 10 ХОНОГ ҮРГЭЛЖИЛСЭЭР”:

2024 оны 09 сарын 09-ны өдрөөс эхлэн сумын хүүхдийн цэцэрлэгт суралцаж буй 2-5 хүртлэх насны хүүхдэд ТОМУУ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ нэмэлт дархлаажуулалт хийгдлээ. Дархлаажуулалт нь эмчийн үзлэг /сумын их эмч, хүүхдийн цэцэрлэгийн их эмчийн/, дархлаажуулалтын сувилагчийн тарилга доор явагдлаа.

Мөн цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор сургуулийн өмнөх боловсролын 7 бүлгийн багш нарт "Улаанбурхан өвчин гэж вэ? түүний шинж тэмдэг талаарх мэдээллийг бэлтгэн түгээв.

Улирлын чанартай холбоотой "Томуу томуу, төст өвчнөөс сэргийлэх" зөвлөмжийг асран хамгаалагч нарт зориулан түгээх 40 ширхэг гарын авлагыг тараасан.



2024.09.13 өдөр Ерөнхий боловсролын сургууль дээр зохион байгуулагдаж буй "HAPPY-40 МИНУТ" танхимын бус сургалтын үйл ажиллагааны хүрээнд 5а ангийн оюунлаг сурагчид маань эрүүл мэндийн төвд хүрэлцэн ирж эрүүл мэндийн зөв дадал хэвшилд суралцлаа. Үүнд:

А. Эрүүл хүүхэд - Монголын ирээдүй учир Шүд эрүүл бол бие эрүүл сэдэвт шүдний эрүүл ахуй, шүдээ зөв угаах дадал хэвшилд дадлагажих.

Б. Хүүхэд бүр амтанд дуртай байдаг. Иймд өөрийн дуртай амтанд агуулагдаж буй сахарын агууламжийг хэрхэн харах, бодох танин мэдэхүйн үзүүлэн сургалт хэлбэрээр сурагчдад мэдлэгийг түгээн ажилласан.

Сургалтын дараа: "Өдөр бүр нэг аяга сүү ууж хэвшицгээе"

Шүдний сойзыг улирал тутамд шинэчлэн сольж хэвшицгээе уриалгыг дэвшүүлсэн.



Тав. Боловсрол, соёлын чиглэлээр:

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн Б. Энхнаран багштай 11г анги, Дарьганга сумын ЕБ-ын 11а ангийн сурагчид туршлага солилцох нөхөрсөг уулзалтыг 9 сарын 22ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Энэхүү уулзалтаар тус ангиуд өөрсдийн сургууль, анги хамт олны онцлог, ангийн ажлын зохион байгуулалт, туршлага, сурагчдын хичээлээс гадуурх хамрагддаг сурагчдын оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа зэргээр харилцан туршлага солилцов.

Дарьганга сумын хүүхдийн цэцэрлэгийн БИДНИЙ БҮТЭЭСЭН 60 ЖИЛ ойн баярын арга хэмжээний нээлтийг 2024.09.16 нд зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын нэрэмжит “АХМАД-2024” тэмцээнд сумаас 7 төрөлд 27 ахмад оролцож, “Шугаман бүжиг”-ийн тэмцээнд тэргүүн байр, уг тэмцээний 60 аас дээш насны ангилалд тусгай байрт тус тус шалгарсан.



СОЁЛЫН ТӨВ:

1.“Эх хэлний өдөр”-т зориулсан хэлний чиглэлээр сэдэвчилсэн ном хэвлэлийн “Эх хэлээ эрхэмлэн дээдэлье” номын үзэсгэлэн гаргаж ард иргэд хүүхэд багачууд,залуу үеийнхэнд танилцууллаа. Хамрагсад-158

Эх хэлний тухай “Номын тойм ,ярилцлага ,уншлага “-ыг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад “ Бидний монгол хэл,бичиг”, “Эх хэл “хэрэглээ” номыг сурталчлан таниулж ярилцлага хийв. Үүнд Дарьганга сумын ЕБС-ийн ахлах ангийн 76 сурагчид хамрагдсан.

Уран бичлэг” -уралдааны бүтээлүүдийг Дарьганга сумын ЗДТГ, Эх хэлний зөвлөл, Соёлын төв хамтран хүлээн авч үзэн материалыг Сүхбаатар аймаг Соёл,Урлаг, Аялал жуулчлал,Залуучуудын газар руу илгээлээ.Уран бичлэгийн уралдаанд байгууллагууд хамрагдсанаас шалгарсан бүтээлүүдийг хүргүүлсэн. Үүнд:

- 1.Бийрийн бичлэг,таталган бичлэг,эвхмэл бичиг,хулсан үзгийн бичвэр
2. Үзгийн хичээнгүй бичиг төрлүүд оролцох бүтээлүүд

Сүхбаатар аймагт “Соёл урлагийн ажилтаны өдөр 2024” арга хэмжээнд байгууллагаараа оролцлоо.

НЭГТГЭСЭН:

ТАМГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ХЯНАСАН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч. БАТБОЛД